



“Усан орчин хамгаалал, менежмент” эрдэм шинжилгээний бага хурал болно



Усан орчны биологи, экологи, экосистемийн үүрэг, ач холбогдол, бохирдлын асуудлуудыг хэлэлцэж, Монгол орны бүс нутгийн онцлогт тохирох усны экосистемийн хамгаалал, менежментийг боловсруулах, хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл гаргах, үнэлгээ, мониторинг, хамгааллын бодлого шийдвэр гаргах түвшинд санал хүргүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулна. Илтгэл, өгүүллийг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл, илтгэлийн PPT файлыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл хүлээн авна. [Эх сурвалж: unuudur.mn /https://bit.ly/3jv2B1M/](https://www.montsame.mn/mn/read/239729/)

Ш.Мягмар: 2025 он гэхэд нийт хүн амын 90 хувийг чанарын шаардлага хангасан баталгаатай усаар хангана



“...АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй хоёр дахь Компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах зорилгоор 350 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлж байгаа. Тус төсөл гурван хэсэгтэй. Ус хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Биокомбинат болон Шувуун фабрик орчимд ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулна. Тэндээс жилдээ 51 сая метр куб ус хэрэглэх боломжийг тогтоогоод байна. Мөн Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулна. Дараагийн ажил нь Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барина. Төв цэвэрлэх байгууламжид цэвэрлэсэн хаягдал усыг тус үйлдвэрт дахин боловсруулж, цэвэршүүлээд дулааны цахилгаан станцын хөргөлтөд өгнө. Дулааны 3,4 дүгээр цахилгаан станцын техникийн хэрэгцээнд хоногт 50 мянган метр куб дахин боловсруулсан усыг өгснөөр жилдээ 18 сая метр куб гүний усыг хэмнэх боломжтой болно. Гурав дахь нь усны уян дэд бүтэц буюу усны засаглалыг бэхжүүлэх юм. Үүнд Усны салбарын холбогдох газрууд хамрагдана ...”. [Эх сурвалж: Монцамэ агентлага /https://www.montsame.mn/mn/read/239729/](https://www.montsame.mn/mn/read/239729/)

Ганцхан өдрийг усгүйгээр төсөөлөөд үзэцгээе!



Imagine a Day Without Water
October 21, 2020

Төсөөлөөд үз дээ, уух усгүй, гараа угаах, шүршүүрт орох, 00-ийн усаа татах, хувцсаа угаах ч усгүй болчихвол ямар байхыг? Усгүйгээр эмнэлгүүд хаалгаа барина. Гал сөнөөгчид галтай тэмцэх боломжгүй, тариаланчид ургацаа услаж чадахгүй, өвчин эмгэг газар авна. 2020 оны 10 дугаар сарын 21-ний энэ өдөр АНУ даяар манай гаригийн бүх амьдралын эх булаг усны үнэ цэнийг олон нийтэд ойлгуулах, бүх нийтийн усны боловсролыг нэмэгдүүлэх зорилго бүхий Усгүй нэг өдрийг төсөөлцгөөе кампанит ажлыг зургаа дэх жилдээ зохион байгууллаа. [Эх сурвалж: Монголын МСС /https://mca-mongolia.gov.mn/news/aquapedia/imagine-a-day-without-water/](https://mca-mongolia.gov.mn/news/aquapedia/imagine-a-day-without-water/)

Усны газар залуу эрдэмтэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа



Усны газар нь усны салбарын бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор залуу эрдэмтэн, судлаачдын усны засаглалыг бэхжүүлэх арга, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмэр, санал санаачилга, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоор зорилгоор салбарын залуу эрдэмтэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Томилгоо



БОАЖЯ-ны Усны бодлого зохицуулалтын газрын даргаар Д.Мөнхбатыг томилсон байна. Тэрээр өмнө нь Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтнээр ажиллаж байв. [Эх сурвалж: БОАЖЯ](https://www.montsame.mn/mn/read/239729/)

Товч мэдээлэл

⇒ БОАЖ-ын сайд Д.Сарангэрэл ХБНГУ-ын Элчин сайдын яамны Хөгжлийн хамтын ажиллагааны дарга Ё.Шнайдерийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр орны байгаль орчны хамтын ажиллагаа ой, биологийн олон янз байдал, тусгай хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн талаар санал солилцож, байгаль орчны чиглэлээр хүүхэд, багачуудад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг түлхүү хийхээр ярилцжээ. [Эх сурвалж: https://ikon.mn/n/20m2](https://ikon.mn/n/20m2)

“Усны асуудлыг шийдэж чадсан хэн боловч Нобелийн хоёр шагнал хүртэх эрхтэй – нэг нь Энхтайваны, нөгөө нь Шинжлэх ухааны”

— АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч Жон Кеннеди